



**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2017 оны 08 сарын 18 өдөр

Дугаар А/60

Улаанбаатар хот

Журам батлах тухай


Монгол Улсын “Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 29.2, “Байгууллагын нууцын тухай хууль”-ийн 2.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус Эрүүл мэндийн төвийн “Байгууллагын нууцыг тогтоох, хадгалах, хамгаалах талаар дагаж мөрдөх журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, нууцын баримт бичгийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Байгууллагын нууц тогтоох, хадгалах, хамгаалах, хамгаалах талаар дагаж мөрдөх журам”-аар тогтоосон зохион байгуулалтын дэг журмыг хатуу сахиж, журамд заасан шаардлагыг биелүүлж ажиллахыг төвийн нийт эмч, ажилтан ажилчдад үүрэг болгосугай.

3. Байгууллагын нууцыг тогтоосон журмын хэрэгжилт, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг хүний нөөцийн менежер/Ц.Энхбаясгалан/, дотоодын хяналт, авилгалтай тэмцэх эрх бүхий мэргэжилтэн /Н.Эрдэнэсүвд/ нарт үүрэг болгосугай

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Э.БОДЬЦЭЦЭГ

3 170 70 0582

Хан-Уул Эрүүл мэндийн төвийн даргын
2017 оны 08 сарын 18 - ний өдрийн
1/60 тоот тушаалын хавсралт 1.....



“БАЙГУУЛЛАГЫН НУУЦ”-ЫГ ТОГТООХ, ХАДГАЛАХ, ХАМГААЛАХ ТАЛААР ДАГАЖ МӨРДӨХ ЖУРАМ

Нэг. Үндэслэл

1.1. Монгол Улсын Их хурлын 1995 оны 05 сарын 16-ны өдөр баталсан “Байгууллагын нууцын тухай хууль”-ийг хэрэгжүүлэх зорилгоор Үндсэн хууль, хууль тогтоомжийн бусад актуудыг үндэслэн байгууллагын нууцыг тогтоох, хадгалах, хамгаалах үйл ажиллагаанд энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Байгууллагын нууцыг бат найдвартай хадгалж хамгаалах үндсэн зорилго нь энэхүү журмаар тогтоосон ажлын зохион байгуулалтын нарийн дэг журмыг хатуу сахиж журамд заасан шаардлагыг бүрэн биелүүлэхэд оршино.

1.3. Тус Эрүүл мэндийн төвийн дарга нь энэхүү байгууллагын нууцын асуудлыг удирдлагаар хангаж тогтоосон журмын хэрэгжилт, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллана.

Хоёр. Байгууллага, байгууллагын нууцын тухай ойлголт

2.1. Байгууллага, байгууллагын нууц гэдгийг “Байгууллагын нууцын тухай хууль”-ийн 3 дугаар зүйлд зааснаар дараах утгаар ойлгоно.

2.1.1. “Байгууллага” гэж тодорхой чиг үүрэг, бүрэн эрх бүхий хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн хуулийн этгээдийг хэлнэ.

2.1.2. “Байгууллагын нууц” гэж хүний эрх, нэр төр, алдар хүнд, тухайн байгууллагын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор холбогдох хуулиар нууц гэж тогтоосон мэдээ, баримт бичиг, биет зүйлсийг хэлнэ.

Гурав. Байгууллагын нууцыг тогтоох

3.1. Байгууллагын албан үйл ажиллагааны онцлогтой холбоотой, шударга өрсөлдөөнд зах зээл, давуу талаа хамгаалах зорилгоор байгууллага өөрөө нууцалж хамгаалалтдаа авсан, задруулбал хууль ёсны ашиг сонирхолд хор уршиг учруулж болох нууц мэдээ, технологийн шийдэл, төсөл, судалгаа шинжилгээний баримт бичиг, шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг байгууллагын нууцад хамааруулна.

3.2. Байгууллагын нууцыг тогтоох, хамгаалахын тулд “Байгууллагын нууцын тухай хууль”-ийн 3.2 дахь хэсэгт хамаарах нууцыг байгууллага өөрөө тогтооно гэж заасны дагуу дараахь байдлаар тогтооно.

3.2.1. Байгууллын санхүүгийн үйл ажиллагаа жил, улирлын баланс, хөрөнгө оруулалт, /албан хаагчдын нийгмийн асуудалтай холбоотой захирамж тушаал, хамт олны хурлын шийдвэр/

3.2.2. Байгууллагын үйл ажиллагааны хөтөлбөр төлөвлөгөө, албан хаагчийн хувийн хэрэг, тоо бүртгэл, цалингийн цэс, сүлжээ.

3.2.3. Байгууллагын үйл ажиллагааны онцлогтой холбоотой хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, судалгаа, шинжилгээний баримт бичиг.

3.2.4. Байгууллагын нууцлалтай холбоотой мэдээлэл хадгалсан компьютерийн программ, сүлжээ, диск, файл.

3.3. Байгууллага дор дурьдсан мэдээллийг нууцалж болохгүй.

3.3.1. Тухайн байгууллагын явуулж буй үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж буй техник, технологийн хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул учруулж болзошгүй бүх төрлийн хорт, цацраг идэвхт бодисын хор хөнөөлийг тодорхойлсон мэдээлэл.

Дөрөв. Байгууллагын нууцыг хадгалах, хамгаалах

4.1. Байгууллагын нууц нь тухайн байгууллагын хамгаалалтанд байна. Байгууллага нь нууцаа хамгаалахын тулд энэхүү журмыг дагаж мөрдөнө.

4.2. Байгууллагын хариуцаж байгаа эсвэл түүнтэй албан үүрэг, мэргэжлийн үйл ажиллагааны дагуу танилцсан, олж мэдсэн этгээд нууцыг чанд хамгаалах үүрэгтэй. Үүний тулд тухайн байгууллагын нууцад хамаарах шийдвэр, төсөл, тайлан, мэдээ, мэдээлэл, санал асуулгын дүн зэргийг гадны ямар нэгэн байгууллага, хувь хүмүүст удирдлагын албан ёсны зөвшөөрөлгүй мэдээлэх, танилцуулах, хувилж олшруулаж өгөх, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлахыг энэхүү журмын дагуу хатуу хориглоно.

4.3. Байгууллагын нууц баримт нь “Архивын тухай хууль”-ийн дагуу нийслэлийн архивт шилжүүлэх хүртлэх хугацаанд нууцын зэрэглэлд хамаарагдана.

Тав. Байгууллагын нууцтай танилцах

5.1. Хуулиар тусгайлан эрх олгогдсон байгууллага, тэдгээрийн ажилтан нь хянан шалгах бүрэн эрх, чиг үүргийнхээ дагуу байгууллагын нууцтай танилцана.

5.2. Байгууллагын нууцтай албан үүргийнхээ дагуу танилцсан буюу олж мэдсэн этгээд зөвхөн хууль тогтоомжид заасан үндэслэл, журамд нийцүүлэн ашиглах бөгөөд бусадад задруулахыг хориглоно.

5.3. Эрх бүхий байгууллага, албан тушаалтан бүрэн эрхийнхээ дагуу хэрэгжүүлж байгаа хяналт шалгалтын явцад хууль тогтоомж зөрчиж нууцалсан байгууллагын нууцыг ил болгох эрхтэй бөгөөд тухайн шалгалтаар илэрсэн зөрчил,

Хан-Уул Эрүүл мэндийн төвийн даргын
2017 оны 18 сарын 18 - ний өдрийн
№60 тоот тушаалын хавсралт 2

ХАН-УУЛ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ХЭМЖЭЭНД МӨРДӨХ
НУУЦ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

№	Нууц баримт бичгийн нэр	Байгууллагын нууцын ажилтан дээр хадгалах	Хариуцах эзэн
1	Байгууллагын үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө буюу хөгжлийн хөтөлбөр	Бичиг хэргийн ажилтан	Эрүүл мэндийн төвийн дарга
2	Байгууллагын үндсэн ажиллагааны болон боловсон хүчний чиглэлээр гаргасан тушаал, хурлын тэмдэглэл, эдгээрийг хадгалсан компьютерийн программууд	Бичиг хэргийн ажилтан	Хүний нөөцийн менежер
3	Байгууллагын хөрөнгө санхүүтэй холбоотой материалууд	Бичиг хэргийн ажилтан	Ерөнхий нягтлан бодогч
4	Өвчний түүхүүд	Бичиг хэргийн ажилтан	Даатгалын эмч
5	Байгууллагын цахимын хаяг, хаягийн нууцлал	Бичиг хэргийн ажилтан	Бичиг хэргийн ажилтан